



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/30

Өвт

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.4, 46.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг үндэслэн Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх ажлыг "Батгэгээн хангай" хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. "Батгэгээн хангай" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч (Б.Ууганчимэг)-т даалгасугай.

3. Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх хүүхдийн хоолны зардалд 81,998,000 (наян нэгэн сая есөн зуун ерэн найман мянган) төгрөгийг гэрээний дагуу санхүүжүүлэхийг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ц.Ганцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

Бат-Өлзий сумын ЕБС
(Тамга, тэмдэг)



(Гарын үсэг)

ЕБС-ийн Захирал Б. Ууганчимээ

НИЙЛҮҮЛЭГЧ

"Батгэгээн хангай" ХХК
(Тамга, тэмдэг)



(Гарын үсэг)

"Батгэгээн хангай" ХХК-ы Захирал: Д. Лхагвасүрэн

Бат-Өлзий сумын ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тендер

ӨВАБӨСЗДТГ/202205031

Өвөрхангай аймаг

Нэг талаас **Бат-Өлзий сумын ЕБС** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Батгэгээн хангай" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, цагаар үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Бараа" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **81998000 (наян нэгэн сая есөн зуун ерэн найман мянга)** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч "Батгэгээн хангай" ХХК-ы харилцах **ХААН** банкны **5542022222** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; ✓
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт; ✓
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл; ✓
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл; ✓
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт; ✓
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь; ✓

- 4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр: Баясгалан
Нэр: Ууганчимэг
Албан тушаал: ЕБС-ийн захирал
Ажлын утас:
Гар утас: 99038210
Цахим шуудан: buuganaa1011@gmail.com
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр: Дондогсэрчин
Нэр: Лхагвасүрэн
Албан тушаал: "Батгэгээн хангай" ХХК-ы захирал
Ажлын утас:
Гар утас: 99049958
Цахим шуудан:
- 5. Нэмэлт нөхцөл:
 - 5.1 Дотуур байрны хүүхдийн хоолны санхүүжилтийг нэг сурагчид нэг өдрийн 3472,50 төгрөгөөр тооцож, сар бүрийн эцэст нэхэмжлэлийн баримт үндэслэн олгоно.
 - 5.2. Хоолны цэсэнд тусгагдсан сүү цагаан идээг /орон нутгийн гаралтай аарц, сүү гэх мэт/ тогтмол нийлүүлэх
 - 5.3. Орон нутагт үйлдвэрлэгдсэн төмс, хүнсний ногоогоо жилийн турш худалдан авч үдийн цайнд хэрэглэх
 - 5.4. Дотуур байрны хүүхдийн хоолны цэсэнд тусгагдсан бүтээгдэхүүний нэр төрлийг өөрчлөхгүй байх
 - 5.5. Нийлүүлэгч нь тендерт ирүүлсэн үнээр хоол хүнсийг нийлүүлэх
 - 5.6. Нийлүүлэгч нь захиалагч байгууллагын бараа бүтээгдэхүүнээ өөрийн унаагаар цаг тухай бүрт авч ирж хүлээлгэн өгөх
 - 5.7 Нийлүүлэгч газар нь тухайн техникийн тодорхойлолт, ТӨӨЗ.15.10, ТӨӨЗ.18.1/д/-ын стандартыг баримтлах
 - 5.8 Дараагийн тендерийн эрх олгогдох хугацаа хүртэл өмнөх тендерийн үнээр бүтээгдэхүүн нийлүүлэх
- 6. Гэрээ цуцлах үндэслэл:
 - 6.1. Тендерт ирүүлсэн үнийн санал зөрчигдсөн
 - 6.2. Дотоод хяналтын комисс, эцэг эхийн санал гомдлоор удаа дараа зөрчил гаргасан нь батлагдсан тохиолдолд
 - 6.3. Бараа бүтээгдэхүүнээ цаг алдаж ирүүлсэн
 - 6.4. Хүнсний чанарын баталгаагүй бүтээгдэхүүн нийлүүлсэн
- 7. Гэрээний хүчинтэй хугацаа:
 - 7.1. Дараагийн тендерийн эрх олгогдох хугацаа хүртэл дагаж мөрдөнө.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕБС-ийн захирал: Б. Ууганчимэг
[Гарын үсэг]



НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Батгэгээн хангай" ХХК-ы захирал: Д. Лхагвасүрэн
[Гарын үсэг]

